



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот  
7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090  
Утас: 70592439, 70592208, 70593208  
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2024-01-31 № 02/36

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА М.БАЯРСҮХ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хүргүүлж байна.

Албан шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг арилган, заасан хугацаанд хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт..... хуудас

ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

002 24 143



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 32/А/1290316

Мандалговь

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгийг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулаагүй **116,270,194.00** /нэг зуун арван зургаан сая хоёр зуун далан мянга нэг зуун ерэн дөрвөн/ төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталж санхүүжүүлсэн.

Энэ нь МУЗГ-ын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2-т /барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөл болон төсөвтэй байх/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөж зарцуулахгүй, байх, хууль журмыг мөрдөж ажиллах;

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Дэлгэрцогт сумын Засаг дарга

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

М.Баярсүх, Засаг даргын орлогч Л.Золжаргал, Нягтлан бодогч Г.Дэжидсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР

 Т.БАТСАЙХАН

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Р.МӨНХТОГТОХ



ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛГЭЙ АСУУЛДЫН БҮРТЭЛ

Байгууллагын нэр: Дэлгэрцогт сумын ОНХС  
Тайлант хугацаа: 2023.12.30

№	Ажил гүйцэтгэлийн ангил, дансны үндэслэл, тодруулга	Алдаа, зөрчилдэй гомч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагас гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгалдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
1	Зардал	ОНХС-ийн хөрөнгийг магадсалин ерөнхий дүгнэлтээр баталгаажуулаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулахыг баталж санхүүжүүлсэн.	116,270,194.00	Албан шаридагч хургуулах	Засаг дарга М.Баярсүх, Засаг даргын орлогч Л.Золжаргал, Нэгтгэсэн бодогч Г.Дэвжидсүрэн 2024 оны 01 дүгээр сарын 30-ны танвилауулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн	Магадсалин ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байх	Зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаридагч хургууласан	Засаг дарга, Засаг даргын орлогч Нэгтгэсэн бодогч	М.Баярсүх Л.Золжаргал Г.Дэвжидсүрэн
Нийт дүн			116,270,194.00						

Т.БАТСАЙХАН  
Х.НАРАНЦАДРАЛ  
Р.МӨНХТОГТОХ

АХЛАХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ЗАСАГ ДАРГА  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.БАЯРСҮХ  
Л.ЗОЛЖАРГАЛ  
Г.ДЭВЖИДСҮРЭН